



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2017 оны 5 дугаар
сарын 24-ний өдөр

Дугаар 150


Улаанбаатар
хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Монгол Улс, БНХАУ-ын хооронд байгуулсан “Иж бүрэн стратегийн түншлэлийн харилцаа хөгжүүлэх тухай хамтарсан тунхаглал”-ыг хэрэгжүүлэх зорилгоор “Монгол-Хятадын Экспо” арга хэмжээг зохион байгуулах бэлтгэл ажлыг ханган удирдан чиглүүлэх, төр, хувийн хэвшлийн байгууллагын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах үүрэг бүхий Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралт ёсоор шинэчлэн байгуулсугай.

2. “Монгол-Хятадын Экспо” арга хэмжээг зохион байгуулах ажлын төлөвлөгөө, шаардагдах зардлын төсвийг тухай бүр батлуулан бэлтгэл ажлын явц, үр дүнгийн талаар Засгийн газарт танилцуулж ажиллахыг Ажлын хэсэгт, уг арга хэмжээг зохион байгуулахтай холбогдуулан эрхэлсэн ажлынхаа хүрээнд хамаарах асуудалд бүх талын дэмжлэг үзүүлж ажиллахыг Засгийн газрын гишүүдэд тус тус даалгасугай.




Монгол Улсын Ерөнхий сайд

Ж.ЭРДЭНЭБАТ

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн
үйлдвэрийн сайд

П.СЭРГЭЛЭН



Засгийн газрын 2017 оны 150 дугаар тогтоолын хавсралт

“МОНГОЛ-ХЯТАДЫН ЭКСПО” АРГА ХЭМЖЭЭГ ЗОХИОН БАЙГУУЛАХ БЭЛТГЭЛ АЖЛЫГ ХАНГАХ, УДИРДАН ЧИГЛҮҮЛЭХ, ТӨР, ХУВИЙН ХЭВШЛИЙН БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ УЯЛДУУЛАН ЗОХИЦУУЛАХ ҮҮРЭГ БҮХИЙ АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

- | | |
|-----------|---|
| Дарга | -Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд |
| Дэд дарга | -Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга |
| Гишүүд: | -Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Төрийн нарийн бичгийн дарга; -Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны Төрийн нарийн бичгийн дарга; -Шадар сайдын Ажлын албаны дарга бөгөөд ахлах зөвлөх; -Засгийн газрын ахлах референт; -Хил хамгаалах ерөнхий газрын дарга; -Соёл, урлагийн газрын дарга; -Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын дарга; -Гаалийн ерөнхий газрын дэд дарга; -Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дэд дарга; -Иргэний нисэхийн ерөнхий газрын дэд дарга; -Гадаад харилцааны яамны Гадаад худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны газрын захирал; -Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга; -Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга; -Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Хөнгөн үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга; -Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Жижиг, дунд үйлдвэр, хоршооны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга; |

-Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга;

-Барилга, хот байгуулалтын яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга;

-Зам, тээврийн хөгжлийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга;

-Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга;

-Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Хүнд үйлдвэрийн бодлогын газрын дарга;

-Эрчим хүчний яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга;

-Эрүүл мэндийн яамны Эм, үйлдвэрлэл, технологийн газрын дарга;

-Татварын ерөнхий газрын Төрийн захиргааны удирдлагын газрын дарга;

-Үндэсний хөгжлийн газрын Салбарын хөгжлийн бодлого, зохицуулалтын хэлтсийн дарга;

-Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхимын орлогч дарга (тохиролцсоноор).

Нарийн бичгийн
дарга

-Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Худалдаа, нийтийн хоол, үйлчилгээний зохицуулалтын хэлтсийн дарга.